

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын
 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн
 02/1272 дугаар албан бичгийн
 3 дугаар хавсралт



ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН
 БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ
 ХҮСНЭГТ (2025 он)

Д/д	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот	Хүрсэн	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан (дотоод сургалт)	1.1	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	-	39	Тус газрын газрын албан хаагчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр 3 удаа сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, давхардсан тоогоор 45 албан хаагч хамрагдсан. Үүнд: Монголын Барилгын зураг төсөл зохиогчдын холбоо болон Монголын Барилгын Инженерүүдийн холбоотой хамтран хотын стандарт, нормыг мөрдүүлж, төрийн хяналт шалгалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа улсын байцаагчийн ур чадварыг сайжруулах, хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 35 албан хаагч хамрагдсан бөгөөд сургалтад оролцсон албан хаагчдад "Сертификат" олгож ажлын үр дүнг баталгаажуулж ажилласан.
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	-	28	
			Мэргэшүүлэх сургалт	-	2	
			Туршлага солилцох арга хэмжээ	-	2	
			Бусад	-	7	
		1.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	618	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	300	
			Эрэгтэй албан хаагч	-	318	
			Удирдах албан тушаалтан	-	6	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	70	
1.3	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал:	-	85%			

			Нийт албан хаагчдад эзлэх хувь			
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан (гадаад сургалт)	2.1	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-	5	Тус газрын албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр гадаадын сургалт, зөвлөгөөний хөтөлбөрт нийт 5 удаа хамрагдсан. Зөвлөгөөнд 28 албан хаагч томилогдон ажилласан. Үүнд: 2025 оны 04 дүгээр сарын 20-ноос 25-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос улсад барилга, дэд бүтэц хот байгуулалтын тогтолцоо, стандартын хэрэгжилт, дэвшилтэт технологийн талаар сургалт, зөвлөгөөнд албан хаагч 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 07 дугаар сарын 30-ны өдрийн хооронд Бүгд Найрамдах Энэтхэг улсын "Хайдерабад"-ын их сургуулийн "Course in Progress to proficiency in english literation-I" сургалтад 1 албан хаагч 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс 10 дугаар сарын 04-ний өдрийн хооронд Тайвань Улсын Олон улсын газрын бодлого судалгаа, сургалтын төвөөс (ICLPST) зохион байгуулсан "Дэд бүтцийн хөгжил ба төлөвлөлт" сэдэвт сургалтад 1 албан хаагч Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотод газрын харилцаа, хот байгуулалт, барилга, дэд бүтцийн хяналтын тогтолцоо, хууль тогтоомж, стандартын хэрэгжилт, техник, технологийн талаарх сургалт, зөвлөгөөнд 10 албан хаагч
		2.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	21	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	10	
			Эрэгтэй албан хаагч	-	11	
			Удирдах албан тушаалтан	-	5	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	11	
		2.3	Гадаад сургалтад хамруулсан байдал:	10-аас дээш	5	

						Америкийн нэгдсэн Улсын ЮТА мужийн Солт Лэйк хотод 2025 оны 10 дугаар сарын 18-26-ны өдрүүдэд 1 албан хаагч туршлага судлах зөвлөгөөнд хамрагдсан. Тус үйл ажиллагааны үед Нийслэлийн ИТХ-ын дарга болон Солт Лейк хотын захирагч Женни Вилсон нар хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурж хамтын ажиллагааг дэмжиж ажиллахыг илэрхийлэв.
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал	3.1	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	Нийслэлийн Хяналт шалгалтын газрын 2025 оны сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг Газрын даргаар 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр баталсан. Энэхүү төлөвлөгөөнд 7 зорилт, 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг 9 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 168 албан хаагчийг хамруулсан. Үүнд:		
						<ul style="list-style-type: none"> - Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбооноос хяналт шалгалтын хөтөлбөрийн хүрээнд хамтарч ажиллах албан бичгийн дагуу улсын байцаагчдыг чадавхжуулах 32 цагийн багц сургалтыг Барилгын эрчим хүчний хэмнэлтийн үр ашиг" сэдвийн дор 3 сарын 17, 22, 23, 29, 30-ны өдрүүдэд сургалтыг зохион байгуулж 20 албан хаагч хамрагдсан. - Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалт, Архив албан хэрэг хөтлөлтийн сургалт болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс сар бүр зохион байгуулагддаг сургалтуудад давхардсан тоогоор 70 гаруй албан хаагчдыг хамруулав. - Барилга угсралтын салбарт угсармал бетон хийцлэл эргэн нэвтэрч буйтай холбоотойгоор угсралтын үеийн технологийн горим, аргачлалтай танилцах хэрэгцээ шаардлага үүсэж байх ба албан хаагчдыг бүтээгдэхүүн болон угсралтын үеийн үйл ажиллагаатай танилцуулах, харилцан мэдлэг, мэдээлэл солилцох зорилгоор "Эн си ди Прекон" ХХК-тай хамтран 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр Гарден сити хаус төслийн хүрээнд 2-4 давхар угсармал хийцтэй амины сууцнуудыг угсармал бетон эдлэлээр хийж гүйцэтгэж буй төслийн талбай болон үйлдвэртэй танилцах сургалтыг зохион байгуулж 45 албан хаагчийг хамруулав. - Монголын Барилгын Инженерүүдийн холбоотой хамтран 2025 оны 10 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд "Улсын байцаагчдыг мэргэшүүлэх багц сургалт"-сэдэв сургалтыг зохион байгуулж 15 албан хаагчийг хамруулсан. Мөн Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/05 дугаар тушаалын

				<p>хавсралтаар баталсан “Мэдээллийн цагийн хуваарь”-ийн дагуу нийт 13 сэдвээр сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 263 албан хаагчийг хамруулж ажилласан. Нийт 28 сургалт зохион байгуулж ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд дараах төсвийг зарцуулж ажилласан. Үүнд: 1. Дотоодод зохион байгуулсан сургалтад 18,351 сая төгрөг зарцуулж ажилласан.</p>	
4	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	4.1	Албан хаагчдын шилжилт	2025 оны байдлаар албан тушаалд дэвшүүлэн томилсон-2, ажлаас чөлөөлсөн 28, байгууллага хооронд шилжин ажилласан-2, нэгж хооронд шилжүүлэн ажилласан 13 нийт шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна.	
		4.2	Шатлан дэвшүүлсэн албан хаагчийн тоо	2	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	1	
			Эрэгтэй албан хаагч	1	
			Удирдах албан тушаалтан	-	
		4.3	Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	2	
			Шилжүүлсэн болон сэлгэн ажиллуулсан албан хаагчийн тоо	13	-
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	7	-
			Эрэгтэй албан хаагч	6	-
			Удирдах албан тушаалтан	1	-
Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	12		-		
Нийгмийн баталгааг хангах хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ					
5.	Албан хаагчид олгосон цалин урамшуулал, нөхөх төлбөр, тусламж, дэмжлэг		83,291,625 төгрөг	Төрийн захиргааны албан хаагчид 2025 оны эхий хагас жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр төрийн захиргааны 39, төрийн үйлчилгээний 16 нийт 54 албан хаагчид урамшуулал олгож ажилласан. Урамшуулалд 83,291,625 төгрөг зарцуулж ажиллаж байна. Жилийн сүүлийн үнэлгээний баг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хуралдаж нийт албан хаагчдын үнэлгээг хянан баталгаажуулж ажилласан. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар одоогоор урамшуулал олгох эсэх нь тодорхойгүй байна.	

5.1.Улирлын урамшуулал олгосон байдал	Нийт албан хаагчийн тоо	55	-	
	Урамшуулал олгосон албан хаагчийн тоо	54	-	
	Үүнээс	удирдах	4	-
		гүйцэтгэх	50	-
	Нийт олгосон урамшууллын хэмжээ	83,291,625 төгрөг	-	
	Үүнээс	I улирал	-	-
		II улирал	83,291,625 төгрөг	-
		III улирал	-	-
		IV улирал	-	-
	Цалингийн нийт санд эзлэх хувь	-	Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдэлд зарцуулсан зардал 60%-ийг эзэлж байна.	
5.5 Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаанд зарцуулсан зардал, нийт:	Албан хаагчийн тоо	1		
	Нөхөх төлбөрийн хэмжээ	1,693,000		
5.5.1. Ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид 1.5 сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон.	Албан хаагчийн тоо	1		
	Нөхөх төлбөрийн хэмжээ	1,693,000	2025 оны ээлжийн амралтаа ажлын зайлшгүй шаардлагаар биеэр эдэлж чадаагүй 1 албан хаагчид Хөдөлмөрийн тухай хуульд заасны дугаа 1,5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгож ажилласан.	
5.5.2. Орон байраар хангагдахад төрөөс үзүүлсэн дэмжлэг	Албан хаагчийн тоо	4	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/185 дугаар тушаалаар батлагдсан "Албан тушаалын орон сууцанд хамрагдсан оршин суугчдын дагаж мөрдөх журам"-ыг нийт албан хаагчдад танилцуулж, тус журмын дагуу тухайн байгууллагад удаан ажилласан 4 албан хаагчийн мэдээллийг бүрдүүлэн 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 01/531 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Тус хөтөлбөрт хамрагдсан 4 албан хаагчийн 2 нь эхний ээлжийн орон сууцанд хамрагдаж, үлдсэн 2 албан хаагч нь дараагийн ээлжинд хамрагдахаар хүлээгдэж байна.	
	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ	-		

	5.5.3. Албан хаагчдын ажлын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг	Албан хаагчийн тоо	50	<p>Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг болон Эрүүл мэндийн 13 дугаар төвтэй хамтран 2025 оны 2 дугаар сарын 11-нээс 3 дугаар сарын 13-ны хооронд нийт 50 албан хаагчийг эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа. Уг арга хэмжээ тус дүүргийн Нэгдсэн эмнэлгийн Яармаг дахь салбар амбулаторид зохион байгуулагдаж, албан хаагчид эрүүл мэндийн 5 төрлийн шинжилгээнд хамрагдсан байна.</p> <p>Үзлэгийн үр дүн: Шинжилгээнд хамрагдсан 50 албан хаагчаас 6 нь эрүүл буюу ямар нэгэн эмгэг өөрчлөлтгүй оношлогдсон бол үлдсэн албан хаагчдад дараах өвчлөлүүд илэрсэн.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хоол боловсруулах эрхтний архаг эмгэгтэй 18 албан хаагч • Бөөр шээсний замын архаг эмгэгтэй 8 албан хаагч • Дотоод шүүрлийн эмгэгтэй 7 албан хаагч • Зүрх судасны эмгэгтэй 3 албан хаагч • Эрүүл буюу өөрчлөлтгүй 6 албан хаагч <p>Нэмэлт шинжилгээ хийлгэх шаардлагатай</p> <ul style="list-style-type: none"> • Онош тодруулж хэвлийн компьютер хийлгэх 3 албан хаагч • Хөхний нэмэлт шинжилгээ /маммографи хийлгэх/ 4 албан хаагч • Бамбайн нэмэлт шинжилгээ өгөх 5 албан хаагч • Цөсний чулуу буюу хагалгаа хийлгэх заалттай 1 албан хаагч • Элэгний вирус тоолуулах 1 албан хаагч • Цөсний ургацаг хянуулж байх 1 албан хаагч <p>Өөрчлөлт эмгэгтэй илэрсэн нийт 28 албан хаагчийг өдрийн эмчилгээнд хамруулж ажилласан.</p>
	5.5.4. Албан хаагчдын албан байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ Зарцуулсан хөрөнгийн хэмжээ	- 267,612,900	- Тус газрын албан хаагчдын ажил үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөлөөр хангах, ажлын бүтээмжийг

нэмэгдүүлэх зорилгоор шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, орчин үеийн цахим мэдээллийн систем болон бичиг хэргийн хэрэгслээр хангаж ажилласан.

Үүнд:

- Компьютер, тоног төхөөрөмж
- Суурин компьютер 14 ш
- Зөөврийн компьютер 10ш
- Принтер 6ш
- Сканнер 3ш
- Таблет 15ш
- Камер 2ш
- Байцаагчийн энгэрийн камер 15 ш
- Цаас устгагч 2ш
- Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл
- Зуны ажлын хүрэм 87ш,
- Салдаг дотортой куртка 87 ш
- Хөдөлмөр хамгааллын гутал 40 ш
- Толгой хамгаалах каск хэрэгсэл 20 ш
- Усны гутал 50 ш
- Хамгаалалтын малгай 70 ш
- Хөдөлмөр хамгааллын гутал 15 ш
- Хийн маск 5 ш
- Чийг нэвтэрдэггүй хамгаалалтын бээлий 20 ш
- Өдөр тутмын хамгаалалтын бээлий 500 ш
- Багаж, хэрэгсэл
- Лифт, урсдаг шатны дуу чичиргээ, хурд хэмжигч 1 ш
- Тавилга, эд хогшил
- Хурлын сандал 50 ш
- Хурлын ухаалаг индер 1 ш
- Хурлын микрофон 8 ш
- 4. Цахим мэдээллийн систем
- Таймли цаг бүртгэлийн систем
- Хийсэл оюун ухаан суурилсан өгөгдөл боловсруулах программ

				Хяналт шалгалт хийсэн объектын бүртгэлийн гар утасны программ зэрэг байна.
Дундаж биелэлтийн хувь 93%				

Албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр гадаадын сургалт зөвлөгөөнд хамруулсан тухай.

ХЯНАСАН:ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БАЙГАЛМАА

БОЛОВСРУУЛСАН:ХҮНИЙ НӨӨЦИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН




Т.РАЙСА

Албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр гадаадын сургалт, зөвлөгөөнд хамруулсан тухай.



Архивын өрөө - 2024



Архивын өрөө - 2025

